

Ж И Л И Й Н Т А Й Л А Н

2014



АГУУЛГА

4	<i>Алсын хараа</i>
6	<i>Ариг соёл</i>
7	<i>ТУЗ танилцуулга</i>
8	<i>Манлай дэмжигчийн танилцуулга</i>
10	<i>Монголын макро эдийн засаг</i>
10	<i>Банкны сектор</i>
11	<i>Манлай дэмжигчдийн нэгдэл</i>
12	<i>Бүтэц, зохион байгуулалт</i>
13	<i>Бид өсч байна</i>
15	<i>Онцлох үйл явдлууд</i>
16	<i>Нийгмийн хариуцлага</i>
17	<i>Хараат бус аудитын тайлан</i>
18	<i>Санхүүгийн байдлын тайлан</i>
18	<i>Иж бүрэн орлогын тайлан</i>
19	<i>Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага</i>





Ухаан, Хүсэл
Уран сэтгэмж
Улам шинэлэг хамт олноороо
Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөх банк

Бидний Алсын Хараа



Харилцагчид

Харилцагчдыг Халамжлагчид

Дэмжих Хамт Олон

Манлай Дэмжигч



АРИГ СОЁЛ

Бидний оршин тогтнох үндэс

Бизнес гэдэг ухагдахуун нь хүмүүст хэрэгцээтэй байгаа зүйлийг тэдэнд бий болгож өгөөд, түүнийхээ хариуд урамшуулал хүртэх явдал юм. Хүмүүст хэн илүү сайн зүйлсийг, илүү сайхнаар хүргэнэ, тэрээр бусдаасаа илүү амжилттай байна. Тэгэхээр ямар ч бизнес өөрийнхөө бүтээгдэхүүн үйлчилгээг хүлээн авч байгаа эцсийн хэрэглэгчийн төлөө буюу тэдэнд хамгийн сайхан мэдрэмж төрүүлэхийн төлөө оршин тогтнох ёстой гэж бид үздэг.

Хамгийн чухал нүүр царай

Харилцагчидтай өдөр тутам нүүр тулж, шууд харьцдаг энэ багтаа бид өндөр мэдрэмж, чин сэтгэл, харьцааны соёл, мэргэжлийн чадварын шаардлага тавьж байна. Энэ хамт олон маань бидэнд амин чухал бөгөөд харилцагчийн хэрэгцээ, сонголтын талаархи үнэтэй мэдээлэл, санал шүүмжийг бидэнд хүргэн, дутагдалтай байгаа үйлчилгээг Дэмжих Хамт Олноос нэн даруй шаардан сайжруулуулах эрх бөгөөд үүрэгтэй юм.

Халамжлагчдыг бүх төрлөөр

ДЭМЖИХ

Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөж, харилцагч болгонд гайхалтай сайхан сэтгэгдлийг үлдээхийн тулд Халамжлагч нарт маань хэрэгцээтэй байгаа бүхий л төрлийн дэмжлэгийг үзүүлж байх нь Дэмжих Хамт Олны оршин тогтнох зорилго нь юм. Үүнд бүтээгдэхүүн дизайны, үйл явцын (процессын), удирдлагын, эрсдэлийн, зах зээлийн харилцааны гэх мэтчилэн олон төрлийн дэмжлэгүүд багтана.

Халамжлагчдыг дэмжих үлгэр

ЖИШЭЭ

Дэмжих Хамт Олны дотроос Манлай Дэмжигч (уламжлалт нэршлээр: Гүйцэтгэх Захирал) нь харилцагч болгонд гайхалтай сайхан сэтгэгдэл үлдээхийн тулд Халамжлагчдынхаа хамгийн хүчтэй дэмжигч нь байх ёстой бөгөөд Дэмжих Хамт Олныгоо үүнд уриалан дуудах үүрэгтэй юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Бадарчийн ЭРДЭНЭБАТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ариг Банкны ТУЗ-ын дарга ноён Б.Эрдэнэбат нь 2008 оноос одоог хүртэл Эрэл групп ХХК-ний ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Тэрээр ажил хөдөлмөрийн гараагаа 1984 онд Эрэл геофизикийн цогцолбор экспедицид инженерээр эхэлж байсан бөгөөд 1989-1991 онд Эрэл хоршооллын дарга, 1991-2000 онд Эрэл ХХК-ний ерөнхий захирал, 2000-2008 онд УИХ-ын гишүүн, 2004-2008 онд Монгол улсын Засгийн газарт Батлан хамгаалахын сайд, Түлш эрчим хүчний сайдын албан тушаалыг

хашиж байсан. Б.Эрдэнэбат нь төр болон хувийн хэвшлийн байгууллагад удирдах дээд албан тушаал хашсан арвин туршлагатай юм. Б.Эрдэнэбат нь эдийн засгийн чиглэлээр гүнзгий мэргэшсэн бөгөөд ОХУ-ын ШУ-ны Академийн дэргэдэх Олон улсын улс төр, эдийн засгийн судалгааны институтыг 1997 онд эдийн засгийн ухааны дэд доктор, 2000 онд эдийн засгийн ухааны доктор зэрэгтэйгээр дүүргэсэн.

ЭРДЭНЭБАТЫН ЖАРГАЛАН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Э.Жаргалан нь Лондонгийн S.O.A.S Их сургуулийг 2008 онд эдийн засагч мэргэжлээр дүүргэсэн бөгөөд төгссөнөөсөө хойш өнөөдрийг хүртэл Эрэл группт төслийн менежер, захирлаар ажиллаж байна.

ДАВААХҮҮГИЙН СЭРГЭЛЭН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Д.Сэргэлэн нь 2000 оноос Эрэл групп ХХК-ийн ерөнхий захирлаар ажиллаж байна. Тэрээр 1987-1991 онд Улсын геодези, зураг зүйн газарт, 1991-1994 онд Эрэл ХХК-н гадаад харилцааны хэлтэст мэргэжилтэн, 1997-1999 онд Эрэл ХХК-ийн гадаад харилцааны хэлтсийн дарга, 1999-2000 онд Эрэл ХХК-ийн захирлаар ажиллаж байсан туршлагатай бөгөөд ЗХУ-ын /хуучин нэрээр/ Новосибирск хотын Геодези зураг зүйн дээд сургуулийг 1981-1987 Аэрофото геодезийн инженерээр, 1993-1997 онд Отгонтэнгэр их сургуулийг Англи хэлний багш-орчуулагч мэргэжлээр, 1997-1999 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Банк санхүүч мэргэжлээр тус тус дүүргэж 1997 онд ОХУ-ын ШУА-н дэргэдэх Олон улсын улс төр эдийн засгийн судалгааны институтад докторын зэрэг хамгаалсан.


РОЛЬФ ДИЕТЕР ВОРЛЕ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Рольф Диетер Ворле нь банкны сургалт, бизнесийн удирдлага, байгууллагын хөгжил, хүний нөөцийн хөгжил, үйл ажиллагааны болон стратегийн удирдлагын чиглэлээр удирдах түвшний арвин туршлагатай ба 1965 онд ажлын гараагаа Германы Бурбах-д Хадгаламжийн банкны салбарын менежерээр эхэлж, зээлийн хэлтсийн менежер, маркетингийн менежер, банкны удирдах зөвлөлийн даргын албан тушаалуудыг хашиж байсан байна. Тэрээр 1974-1998 онуудад Frankfurt Main Банкны академийн гүйцэтгэх захирлын орлогч, гүйцэтгэх захирал зэрэг албан тушаалуудыг хашиж байгаад 2006 оныг дуустал хугацаанд Потсдам дахь зүүн Германы Хадгаламжийн банкуудын Академийн захирал хийж байсан. 2007-2009 онуудад Монгол улсад Германы Техникийн Хамтын Ажиллагааны нийгэмлэг "Санхүүгийн салбарт үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжих" төслийн удирдагчаар ажиллаж байгаад 2009 оноос өнөөдрийг хүртэл банкны болон удирдлагын зөвлөх үйлчилгээг үзүүлж байна.

БҮРЭНЖАРГАЛЫН ЭРДЭНЭ-САНАА ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Б.Эрдэнэсанаа нь 2008 оноос SFECO ХХК-ний үйл ажиллагаа хариуцсан захирал, Сигнум ресурс корпораци ХХК-ний удирдлагын захиралаар ажиллаж байна. Тэрээр 2007 онд Жерард металс INC Стамфорд Коннектикутэд арилжааны банкны үйл ажиллагаа, бүтцийн санхүүгийн мэргэжилтнээр, 2003-2006 онд Нидерландын ING Банк техникийн туслалцааны хөтөлбөрт ХХБ-ыг удирдаж ажилласан. Мөн 2006-2007 онд ХХБ-ны Санхүүгийн үйлчилгээний дэд ерөнхийлөгч, 2004-2006 онд Иргэдийн банкны үйл ажиллагааны газрын захирал, 1995-1996 онд Карт болон Хяналт шалгалтын хэлтсийн захирал, 1991-1995 онд Банкны үйл ажиллагааны хэлтсийн менежер, Инвеско Консалтинг компанийн захирлын албан тушаалыг хашиж байсан. Б.Эрдэнэсанаа нь 2008-2010 онд Москак компаний, 2001 онд Хаан Банкны, 2000-2001 онд Нэтмон Банк бус санхүүгийн байгууллагын ТУЗ-ын гишүүнээр тус тус сонгогдон ажилласан.

Б.Эрдэнэсанаа нь 1998 онд АНУ-ын Нью-Йорк хотын Рочестрын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй, 1991 онд ОХУ-ын Иркутскийн Эдийн засгийн академийг банкны мэргэжлээр бакалавр зэрэгтэй дүүргэсэн. Тэрээр Американ Экспресс, Виза, Мастер, JCB зэрэг олон улсын төлбөрийн картын сүлжээг Монгол улсад анх удаа нэвтрүүлсэн, MoneyGram олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний сүлжээг улс даяар нэвтрүүлж Монголын банкны салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан банк санхүүгийн салбарын арвин туршлага бүхий шилдэг манлайлагч юм.



АРИГ БАНК

Даваахүүгийн ТӨМӨРХҮҮ

Манлай Дэмжигч

Д.Төмөрхүү нь Бостоны “Уэйнврайт” банкинд харилцагчийн менежер, Бостоны “Смит Барни”-д зөвлөх, Нью Йорк хотын “Ди Жэй Пропертис”-т түншийн удирдлагын менежерээр ажиллаж байсан юм.

Тэрээр АНУ-ын Нью Йорк хотын Пэйс Их сургуулийн Санхүүгийн удирдлагын магистр, Отгонтэнгэр Их сургуулийн Хавсарга хэл шинжлэлийн бакалаврын зэрэг тус тус хамгаалсан.

БИДНИЙ ИЛГЭЭМЖ

Ямар ч бизнес өөрийнхөө бүтээгдэхүүн үйлчилгээг хүлээн авч байгаа эцсийн хэрэглэгчийн төлөө буюу тэдэнд хамгийн сайхан мэдрэмж төрүүлэхийн төлөө оршин тогтнох ёстой гэж бид итгэдэг. Чухам энэ л зорилгод хүрэхийн тулд бид 2014 онд байгууллагаа бүхлээр нь шинэчлэн зохион байгуулан, бүх түвшний ажиллагсад бид, өөрсдийнхөө сэтгэхүйг цоо шинээр сэргээн цэнэглэж эхлээд байна.

Өдөр тутмын үйл ажиллагаандаа хувь хүний харилцааны чадвар, хүнд үйлчлэх хүсэл, эрч хүч, сэтгэл, мэдрэмж гэсэн чанаруудыг нэн тэргүүнд эрэлхийлж, багаа улам бэхжүүлэх, чадваржуулах бодлогыг бид эрхэмлэж байна. Харилцагч болгонд гайхалтай сайхан сэтгэгдэл үлдээх стратегиа хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын шинэ бөгөөд чухал байруудыг бий болгож, хамт олон, хүнд зориулсан хөрөнгө оруулалтаа 2.5 дахин өсгөж ажиллаа. Харилцагчийн Өргөөд (уламжлалт нэршлээр – салбар) болон банкны ДэмжихБайрны(уламжлалтнэршлээр – банкны төв) үйлчилгээний болон ажлын байрны тав тух, тохижилт, өнгө төрхийг бүрэн шинэчиллээ. Биднээс үйлчилгээ авахад шуурхай, хүндрэлгүй байлгахын тулд бид үйл ажиллагааныхаа процессуудыг хялбаршуулж байна. Энэ зорилтынхоо хүрээнд орчин

үеийн шилдэг технологи, техник тоног төхөөрөмжүүдийг ашигласан, Монголд анхдагч болох Swipe, iDual, TCR, цоо шинэ Интернэт банк, 24/7 горимын Утсаар халамжлах төв зэрэг ажлуудад томоохон хөрөнгө оруулалтуудыг амжилттайгаар хийлээ.

Эдгээр сайжруулалт, хөрөнгө оруулалт, шинэчлэлүүд маань бид бүхнийг танд гайхалтай сайхан сэтгэгдлийг үлдээх зорилт өөд маань томоохон алхам хийхэд хүчтэй түлхэц болох ажлууд гэж үзэн бид сэтгэл өндөр байгаа юм.

Бид таныг манай Харилцагчийн Өргөөдөөр зочлохыг урьж байна. Биднийг зорих хэрэг тань санхүүгийн зөвлөгөө авах, гүйлгээ хийх, аяга кофе уух, интернэт хэрэглэх, эсвэл зүгээр мэнд мэдэж, хууч хөөрөхийн аль нь ч байсан гэсэн таныг сайхан сэтгэгдэлтэй үлдээсэй гэж бид хүсч байна.

Ариг Банкны хамт олны чин эрмэлзэл, нөр их хөдөлмөрөөр хийгдэж байгаа сэтгэл догдлуулсан олон шинэ өөрчлөлтүүд болон чанарын сайжруулалтуудыг харилцагчид болон нийт зах зээлд яг л энэ эрч хүч, дүр төрхөөр нь толилуулан хүргэхийн тулд бид стратегийн rebranding буюу брэндийн шинэчлэл хийсэн юм.

Манлай дэмжигч
Даваахүүгийн ТӨМӨРХҮҮ

Монголын макро эдийн засаг

Гадаад эдийн засгийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан ДНБ өсөлт удааширсаар зэрэгцүүлсэн өсөлт 2014 онд нэг оронтой тоо буюу 7.8 хувь болон буурлаа. Оюу Толгой уурхайн эхний ээлжийн хөрөнгө оруулалт үндсэндээ дуусч, Монгол улсад шинээр хөрөнгө оруулалт хийх сонирхол буурсантай холбоотойгоор улсын төлбөрийн тэнцлийн алдагдлыг гадаад валютын нөөцөөр санхүүжилж ирсээр төгрөгийн ам.доллартай тэнцэх ханш 2014 оны эцсээр 1885 төгрөг хүрсэн байна. Нөгөө талаас Засгийн газар болон Монголбанкнаас хамтран хэрэгжүүлсэн орон

сууц болон үнэ тогтворжуулах хөтөлбөрүүдийн санхүүжилтийн дүн буурсан боловч санхүүжилт тогтвортой байгаа учир гадаад хөрөнгө оруулалтын бууралтыг дээрхи хөрөнгөөр орлуулснаар эдийн засгийн өсөлт эерэг гарсаар байна. Оюу Толгой төслийн гүнийн уурхайн санхүүжилт болох 5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын асуудал Монгол улсын засгийн газар болон төслийг хэрэгжүүлэгч компанийн толгой компани болох Рио Тинто нарын хооронд хэрхэн шийдэгдэхээс дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн хурд шалтгаална.

Үндэсний статистикийн хороо



Банкны секторын үзүүлэлтүүд

2014 онд банкны секторын активын хэмжээ 22.5 их наяд төгрөгт хүрснээр ДНБ -й 103 хувь болсон нь улсын хэмжээнд санхүүгийн зуучлалын цар хүрээг илтгэж байна. Нийт активын 20 хувийг засгийн газар болон Монголбанкнаас нийлүүлсэн хөрөнгө эзэлсээр байгаа нь Чингис бондоор босгосон хөрөнгө болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн үр дүн болно. Секторын активын өсөлт тогтворжин 8 хувь болсон. Монголбанк инфляци болон валютын ханшийг тогтворжуулахын тулд бодлогын хүүг 2014 оны 7 сард 1.5 пунктээр нэмж 12 хувь болгосон байна. Мөн

банкны секторыг дэмжих зорилгоор заавал байлгах нөөцийн хангалтыг хөнгөлөн төгрөг валютын нөөцийн дутагдлыг 50 % хүртэл илүүдлээр нь хангаж болохоор бодлогын өөрчлөлт хийсэн. Үүнээс гадна орон сууцны хөнгөлттэй зээлийн орчныг бүрдүүлэх зорилгоор банкуудын баланс дээр байсан 1.1 их наяд төгрөгийн орон сууцны зээлийн багцыг үнэт цаасжуулж худалдан авснаас гадна 350 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкнаас санхүүжүүлсэн байна.

СЕКТОРЫН АКТИВЫН ӨСӨЛТ



22.5 ИХ НАЯД ТӨГРӨГ

ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨСӨЛТ



12.4 ИХ НАЯД ТӨГРӨГ

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ



10 ИХ НАЯД ТӨГРӨГ

Үндэсний статистикийн хороо

МАНЛАЙ ДЭМЖИГЧДИЙН НЭГДЭЛ



Алтангэрэлийн БУЛГАН
Манлай дэмжигч
Хамт олныг халамжлах жигүүр

А.Булган нь 8 жил бизнесийн салбарт ажилласан ба Монголын болон гадаадын хөрөнгө оруулалттай томоохон компаниудад Хүний нөөцийн функцийг амжилттай удирдан чиглүүлж ажилласан туршлагатай. Энэ хугацаанд ажилтнуудын авьяас чадварыг нээн илрүүлэх, шийдвэр гаргалт дахь оролцоог хангах, залуу удирдагчдыг дадлагажуулах, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх асуудлуудыг системтэй хөгжүүлэхэд голчлон анхаарч, хүний нөөцийн дэвшилтэт арга зүйг ашиглан удирдлагын багийг чадавхижуулах хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн. А. Булган нь Сэтгэл зүйч мэргэжилтэй, Унгар улсын Eötvös Lorand-н Их Сургуульд Байгууллагын сэтгэл зүйн чиглэлээр Магистр зэрэг хамгаалсан.



Балданжамцын АМАРЖАРГАЛ
Манлай дэмжигч
Шинэ хөгжилд дагуулах жигүүр

Б. Амаржаргал нь 2014 оны 6 дугаар сараас Ариг Банкны Шинэ хөгжилд дагуулах жигүүрийн Манлай дэмжигчээр ажиллаж байна. Тэрээр Хасбанкинд салбарын захирал, бүсийн захирал зэрэг албан тушаалыг 7 жилийн турш хашиж банкны үйл ажиллагааны удирдлагын чиглэлээр туршлага хуримтлуулсан. 2008-2012 онд Энержи Ресурс ХХК-д Логистик хангамж, Эрсдлийн удирдлага дотоод хяналтын газрын даргын албан тушаалд тус тус ажиллаж байсан. Монгол Улсын Техникийн Их сургуулийг 2003 онд дүүргэж Бизнесийн удирдлагын бакалаврын зэргийг Санхүүгийн менежментээр авсан билээ.



Ганбаатарын МӨНХЗУЛ
Манлай дэмжигч
Зочломтгой ёсны жигүүр

Ганбаатарын Мөнхзул Ариг Банкны Зочломтгой ёсны жигүүрийн манлай дэмжигчийн ажлыг хийж байна. Тэрээр ажилтнуудынхаа хамтаар 7 хоног, 24 цагаар ажилладаг Утсаар Халамжлах Төвөөр дамжуулан хэрэглэгчдийн хүссэнээс давсан үйлчилгээг үзүүлэхээр байнга үйлчилгээнийхээ чанарыг сайжруулан ажилладаг билээ. Мөнхзул нь 2005 онд МУИС-г Орос орон судлалын мэргэжлээр төгссөн ба 2010 онд Бухарестийн Эдийн засгийн сургуульд Европ судлалын чиглэлээр магистрын зэргээ хамгаалсан юм. Тэрээр ажлынхаа замналын туршид байгаль хамгаалал, олон улсын төрийн бус байгууллага, Болгарийн Софи хот дахь мал эмнэлгийн эм ханган нийлүүлэлтийн компани, Улаанбаатар хотод "Эйр Маркет" зэрэг газруудад ажиллаж байсан



Шаравын БАТ-ЭРДЭНЭ
Манлай дэмжигч
Өргөөдийг Залах Жигүүр

Ш.Бат-Эрдэнэ нь 2014 оны 1 сараас Ариг Банкны Өргөөдийг залах жигүүрийн Манлай дэмжигчийн албан тушаалд ажиллаж байна. 2004 онд МУИС-ийн Худалдааны сургуулийг төгсөөд Монгол улсын томоохон арилжааны банкуудын нэг болох ХасБанкнаас ажлын гараагаа эхлүүлсэн ба бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгч нарт санхүүгийн үйлчилгээ хүргэх талаар туршлага хуримтлуулж ажилласан. Тэрээр 2005 онд Азийн Хөгжлийн Банкны тэтгэлгээр Япон улсын Рицүмэйканы Их сургуульд Эдийн засгийн магистрын зэрэг хамгаалсан.



Жавын ГЭЛЭГЖАМЦ
Манлай дэмжигч
Жолоодлогоор дэмжих жигүүр


Ж.Гэлэгжамц нь 2010 оноос өнөөг хүртэл Ариг Банкны Жолоодлогоор дэмжих жигүүрт ажиллаж байгаа бөгөөд 2008-2010 онд Герман улсын Берлин хотноо Миллениум ХХК, системийн шинжээч, эрсдэлийн шинжээчээр ажиллаж байсан туршлагатай. 1991-1996 онд Шинжлэх Ухаан Технологийн Их сургуулийг Дулааны цахилгаан станцын инженерээр, 1999-2007 онд мөн Берлины Техникийн их сургууль, Техник эдийн засгийн сургуулийг эдийн засгийн математикийн чиглэлээр суралцсан.



Батхүүгийн МӨНХБАЯР
Манлай дэмжигч
Технологиор Дэвжүүлэх Жигүүр

Тэрээр бакалаврын зэргээ СЭЗДС-д Бизнесийн удирдлагын чиглэлээр хамгаалсан бөгөөд магистрын зэргээ ШУТИС-д Компьютерийн чиглэлээр хамгаалсан юм. Сүүлийн 18 жилийн туршид Мөнхбаяр нь холбоо, мэдээлэл технологи, програм хангамж, банк санхүү болон худалдаа, импорт, ханган нийлүүлэлт, хадгалалт, эрүүл мэнд, эм зүй, засгийн газар болон төрийн бус байгууллагуудад голчлон удирдах түвшний алба хашсан байна. Түүний зарим албан тушаалыг дурдвал, Мобиком компанид системийн админ ба маркетингийн менежерээр 5 жилийн турш, хамтран байгуулсан програм хангамжийн оутсорсингийн тэргүүлэх компаниудын нэг USI (United Solutions International)-д ерөнхий захирал болон ерөнхий менежерээр 5 жилийн турш, Хасбанкны мэдээлэл технологийн хэлтсийн даргын албан тушаалыг 5 жилийн турш хашсан ба 2014 оноос Ариг Банкинд ажиллах болсон билээ.

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Ариг Банкны удирдах ажилтнууд яагаад хамгийн доор үүдэндээ суудаг вэ?


Олжуулзахад хамгийн хэцүү, арын, тусдаа өрөөнд нуугдан суух биш, харилцагч хаалгаар орж ирэхэд хамгийн ойрхон, ил байснаар өдөр тутмын асуудлуудтай ойр байж, ажилтнуудаа үлгэрээр удирдан, харилцагч болгонд гайхалтай сайхан сэтгэгдэл үлдээх зорилго маань нэг алхамаар ойртоно

гэж Ариг Банкныхан үздэг юм. Та манай Харилцагчийн Өргөөд болон Дэмжих Байраар (Банкны Төв) зочлохдоо манай Манлай Халамжлагч болон Манлай Дэмжигчдийн ширээ, тасалгаагаар саатан, яриа өрнүүлээрэй.

БИД ӨСЧ БАЙНА...

2000
ХЭРЭГЛЭГЧИД

146%
ӨМНӨХ ОНООС
ӨСӨЛТ



- 44% Зах худалдааны төв
- 14% Дэлгүүр, Супермаркет
- 9% Ресторан, кафе, караоке
- 8% Такси, тээвэр
- 7% Төрийн үйлчилгээ
- 4% Банк, санхүүгийн байгууллага
- 2% Үсчин, гоо сайхан
- 11% Бусад

1. Карт уншдаг такси

УБ хотын хэмжээнд нийт 100 гаруй такси Swipe үйлчилгээг ашиглан картнаас төлбөр авч эхэлснээр иргэдийн дунд “Карт уншдаг такси” хэмээх цоо шинэ үйлчилгээг бий болгоод байна.

2. Замын хөдөлгөөний дугуй түгжигч үйлчилгээ

Зогсохыг хориглосон газар автомашинаа байрлуулсан тээврийн хэрэгслийн дугуйг түгжих төрийн үйлчилгээ хэрэгжиж эхэлсэн бөгөөд дугуй түгжсэн цоожыг тайлуулахдаа тухайн жолооч торгуулийн төлбөрөө бэлнээр мөн картаар хийх боломжтой болсон.

3. Даатгалын үйлчилгээ

Даатгалын төлөөлөгч нар дүүргийн авто оношлогоо, худалдааны төв зэрэг үндсэн бус байршил дээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд дээрх цэгүүд ПОС терминал суулгахад хүндрэлтэй байдаг. Харин Swipe үйлчилгээ нь энэ асуудлыг шийдэж байгаа юм.

4. Интернэт, кабель суулгах

Айлын гэрээр явж интернэт, кабель суулгаад үйлчилгээний хураамжаа

заавал бэлнээр биш мөн картаар хийж болно.

5. Бараа хүргэлт, хоол хүргэлт

Мобайл ПОС-н хамгийн гол давуу тал нь хөдөлгөөнт бизнесд ашиглах боломжтой байдаг. Facebook хуудсаар захиалга авч бараа түгээдэг, эсвэл рестораны хоол хүргэгчийн аль нь




ч Swipe-г ашиглаад хүссэн газартаа төлбөр тооцоогоо хийж болно.

Swipe нь зөвхөн дээрх газруудаар хязгаарлагдахгүй төлбөр тооцоо хийгдэж байгаа ямар ч төрлийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой юм.



БИДНИЙ ӨСӨЛТ ХУВИАР...



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



2014.07.25 Ариг Банк болж үйл ажиллагаандаа шинэчлэлийг бодитоор хэрэгжүүлж эхэллээ.



“Хүүхдийн боловсрол” хадгаламжийг 18.2%-ийн хүүтэй болголоо.



Хүүгээс хүү тооцдог хадгаламжуудийг гаргаж харилцагчиддаа өргөн сонголтыг бий болголоо.



Swire мөнгөн урсгалын зээлийг жижиг хэмжээний бизнес эрхлэгчдийг дэмжин гаргалаа.




“Best of Mongolia 2014” нээлттэй санал асуулгаар шилдэг банк боллоо.



Манлай дэмжигч Д. Төмөрхүү Монголын Банкны Холбооны Дэд Ерөнхийлөгчөөр сонгогдож, 2014 оны Шилдэг Банкараар шалгарлаа.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ДАРААЛАЛГҮЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД



Дараалалгүй үйлчилгээ

Өндөр настан, жирэмсэн эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нялх хүүхэдтэй харилцагч нарт дараалал харгалзалгүй үйлчилдэг боллоо.

Байгаль орчныг хамгаалах

Ариг бүрхүүл, Ариг буйданг ажиллагсдынхаа хичээл зүтгэлээр бий болгож байгаль орчныг хамгаалах, хог хаягдалгүй цэвэр орчин бий болгоход нийгмийг уриалан ажиллаж байна



Achilles International Mongolia

Achilles International Mongolia төрийн бус байгууллагыг үүсэн байгуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортоор дамжуулан нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулахад хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна.

Хараат бус АУДИТЫН ТАЙЛАН

Deloitte

Делоитт Онч Аудит ХХК
15 давхар, Ай Си Си цамхаг
Жамьян гүүгийн гудамж
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот, 14240
Монгол улс
Утас: +976 7010 0450
Факс: +976 7013 0450
www.deloitte.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ариг Банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигч танаа:

Бид Ариг Банк ХХК (цаашид "Банк" гэх)-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайланттай холбоотой удирдлагын үүрэг

Санхүүгийн тайлангаа Монгол Улсын Банкны тухай хууль болон Монгол Банкны баталсан журам ("Журам")-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний зөрчилгүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудиторын үүрэг

Аудитор хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Санхүүгийн тайлан нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг зохих магадлагаа олж авахуйцаар аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба өс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг эдгээр стандартуудад шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгыг нотлох нотолгооны зүйлсийг олж авахын тулд гүйцэтгэдэг аудитын горимуудаас бүрдэнэ. Санхүүгийн тайлан алдаа болон санаатай зальт үйлдлийн улмаас материаллагаар зөрчилтэй илэрхийлэгдэх эрсдэлд өгсөн аудиторын үнэлгээнээс хамааран аудитын горимуудыг сонгодог. Аудитор эрсдлийн үнэлгээ хийхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шударгаар тайлагнахад хэрэглэдэг дотоод хяналтыг судалдаг. Энэ нь зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгохтой холбоотой бөгөөд аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно. Үүнээс гадна аудит нь удирдлагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол зохистой эсэх, санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг үнэлэх ажлуудаас бүрддэг.

Бидний олж авсан аудитын нотлох зүйлс нь аудиторын дүгнэлт гаргах хангалттай ба зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Дүгнэлт

Бид, Банкны 2014 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Журмын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Бусад

Энэхүү тайлан нь хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн удирдлага болон хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Делоитт Онч Аудит ХХК

Делоитт Онч Аудит ХХК
Улаанбаатар Монгол Улс
2015 оны 03-р сарын 30-ны өдөр

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

12 сарын 31-нээр тасалбар болгосон 2014 он
(мянган төгрөгөөр)

	2014	2013
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	12,091,007	10,821,382
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	9,058,172	8,540,876
Зээл ба урьдчилгаа	42,528,931	33,844,376
Бусад авлага	1,020,420	1,307,948
Хангамжийн материал	203,039	97,397
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	952,420	879,555
Хойшлогдсон татварын хөрөнгө	157,539	-
Үндсэн хөрөнгө	3,640,899	1,782,866
Биет бус хөрөнгө	369,424	158,253
Нийт хөрөнгө	70,021,851	57,432,653

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Өр төлбөр		
Харилцагчдын харилцах, хадгаламж	44,496,752	24,260,695
Банк, бусад санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	633,154	309,329
Буцаан худалдан авахаар худалдсан үнэт цаас	3,100,000	-
Орлогын татварын өр	-	29,535
Зээл	4,320,800	13,484,670
Бусад өр төлбөр	2,925,345	2,004,000
Нийт өр төлбөр	55,476,051	40,088,229

Эзэмшигчийн өмч

Хувьцаат капитал	16,290,000	16,290,000
Бусад нөөц	3,041	4,041
Хуримтлагдсан (алдагдал)/ашиг	-1,747,241	1,050,383
	14,545,800	17,344,424
Нийт өр төлбөр ба эзэмшигчийн өмч	70,021,851	57,432,653

ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

12 сарын 31-нээр тасалбар болгосон 2014 он
(мянган төгрөгөөр)

	2014	2013
Хүүгийн орлого	8,713,754	8,722,612
Хүүгийн зардал	-4,808,308	-4,313,862
Хүүгийн цэвэр орлого	3,905,446	4,408,750
Хураамж, шимтгэлийн орлого	359,901	228,366
Бусад үйл ажиллагааны орлого	280,900	303,274
Хүүгийн бус цэвэр орлого	640,801	531,640
Нийт хүүгийн цэвэр орлого ба хүүгийн бус цэвэр орлого	4,546,247	4,940,390
Үйл ажиллагааны зардал	-5,290,972	-3,202,449
Болзошгүй эрсдлийн хасагдуулгын зардал	-2,210,438	-537,164
Татварын өмнөх (алдагдал)/ашиг	-2,955,163	1,200,777
Орлогын татварын өгөөж / (зардал)	157,539	-150,394
Тайлант жилийн татварын дараах цэвэр (алдагдал)/ашиг	-2,797,624	1,050,383
Бусад иж бүрэн орлого	-	-
Тайлант жилийн нийт иж бүрэн (алдагдал)/ашиг	-2,797,624	1,050,383

2014 онд шинэ техник технологи нэвтрүүлэх, мэдээллийн технологийн аюулгүй, тасралтгүй байдлыг хангах хүрээнд багагүй ажил хийгдлээ.

Харилцагчийн үйлчилгээ, харилцагчийн мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг өндөр түвшинд хангах зорилгоор харилцагчийг хурууны судасны байрлалаар таних шинэ технологийг Монгол улсын хэмжээнд анх удаа нэвтрүүллээ. Энэ үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагчаас бичиг баримт шаардахгүй, мөн тухайн харилцагчийн дансны мэдээлэл, гүйлгээг өндөр түвшинд нууцлагдах боломжийг хангаж өгсөн юм.

Мөнгө тоолж хүлээн авах үйл ажиллагаа автоматжуулсан TCR буюу "Teller Cash Recycler" төхөөрөмжийг нийлүүлэгч Японы компанитай хамтран амжилттай туршиж нэвтрүүлээд байна.

Дэмжих төвийн сервер тоног төхөөрөмжүүдийг болон өргөөдийн цахилгааны тасралтгүй найдвартай байдлыг өндөр түвшинд хангах тоног төхөөрөмж суурилагдаж, Банкны дата Технологиор Центер буюу сервер тоног төхөөрөмжийн өрөөг шинээр зохион байгуулсан нь банкны мэдээллийн технологийн найдвартай, аюулгүй байдлыг хангах чухал суурь нөхцөл боллоо.



ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ
ХОС ХАМГААЛАЛТААР НУУЦЛАВ





ЖИЛИЙН ТАЙЛАН 2014

Ариг Банк
www.arigbank.mn
facebook.com/arigbank
7013 3060 24/7